



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 821

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 15,808,470,682.12 (арван таван тэрбум найман зуун найман сая дөрвөн зуун далан мянга зургаан зуун наян хоёр төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг болох техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг заалт бүрээр ханган ажиллах, төлөвлөхөд хяналт тавьж ажиллах;

2.2.Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захиралд Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмч эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захиралд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

4.2.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд валютын ханшны алдагдал болон бусад аливаа эрсдэлийг тооцож төлөвлөх;

4.3.Дорноговь аймаг, Улаанбадрах сум, 3 дугаар багт байрлах 8 ширхэг эзэмших эрхийн 239.5 га газрын эзэмших, ашиглах эрхийг үнэлж Төрийн өмчийн

132003126

32-r huraldaan.docx

бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч санхүүгийн тайланд тусгах;

4.3.Дорноговь аймаг, Улаанбадрах сум, З дугаар багт байрлах 8 ширхэг эзэмших эрхийн 239.5 га газрын эзэмших, ашиглах эрхийг үнэлж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч санхүүгийн тайланд тусгах;

4.4.Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхийг таслан зогсоох, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах;

4.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохих зөвшөөрлийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн дансны ангилал солих, шилжүүлж байх;


4.6.Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөн ажиллаж компанийн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах болон анхан шатны баримтын бүрдэл, тайланг үнэн зөв гаргаж байх;

4.7.Компанийн худалдан авах ажиллагааг бүрэн төлөвлөж, үйл ажиллагааг нь сайжруулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт заасны дагуу тендер шалгаруулалтын материалыг архивын нэгж болгон хадгалах;

4.8.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах;

4.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
2024 дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД ХИЙСЭН
ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт	6,664,917,909.62	Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
2	Max махан бүтээгдэхүүний дансны хөтлөлтийг алдаатай гүйцэтгэж, тайланг буруу гаргасан	406,010,812.50	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.
3	Ажлын хувцас худалдан авч бараа материалын дансанд бүртгэхдээ зөрүүтэй дүнгээр тусгасан	283,585,000.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.
4	Бараа ажил үйлчилгээ худалдан аваходаа төсөвт өртгийг хэтрүүлэн худалдан авалт хийсэн.	8,453,956,960.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3, 36.1.5, 36.1.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн:		15,808,470,682.12 (арван таван тэрбум найман зуун найман сая дөрвөн зуун далан мянга зургаан зуун наян хоёр төгрөг арван хоёр мөнгө)	